

ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖИЙН ЖУРАМ

Нэг. Ерөнхий нөхцөл

- 1.1 Энэ журмын зорилго нь “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХКомпани /цаашид хадгалагч гэх/-ийн төвлөрсөн хадгаламжид үнэт цаасыг бүртгэн хадгалах, хадгаламжид өөрчлөлт оруулах, хадгаламжаас хасахтай холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү харилцаанд Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Эрүүгийн хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, “Байгууллагын нууцын тухай” хууль, Хувь хүний нууцын тухай хууль болон “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХКомпанийн журмуудыг удирдлага болгоно.
- 1.3 Үнэт цаасны хадгаламж, хадгаламжийн бүртгэлтэй холбогдсон үйл ажиллагааг хадгалагчийн Хадгаламж, өмчлөх эрх бүртгэл, кастодианы алба /цаашид алба гэх/ хийж гүйцэтгэнэ.

Хоёр. Журмын нэр томъёо

- 2.1 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.
 - 2.1.1 “Үнэт цаас” гэж Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.8-д зааснаар ойлгох;
 - 2.1.2 “Төвлөрсөн хадгаламж” гэж ҮЦТХТөвд биет болон биет бус үнэт цаасыг тоо ширхэг, хувьцаа эзэмшигчдийн нэр хаягаар нь тусгай бүртгэл хөтлөн хадгалах, биет бус үнэт цаасыг файл хэлбэрээр компьютерын санах байгууламжид бүртгэсэн цогц хадгаламж;
 - 2.1.3 “Худалдахаар хүлээгдэж байгаа үнэт цаас” /Pending sell/ гэж худалдах хэлцэл хийгдсэн боловч төлбөр тооцоог Т+3 өдөр хүртэл хүлээж буй үнэт цаас
 - 2.1.4 “Худалдан авахаар хүлээгдэж буй үнэт цаас” /Pending buy/ гэж худалдан авах хэлцэл хийгдсэн боловч төлбөр тооцоо нь Т+3 өдөр хүртэл хүлээгдэж буй үнэт цаас
 - 2.1.5 “Чөлөөт үлдэгдэл”/ balance free/ гэж тухайн харилцагчийн дансан дахь үнэт цаасны эхний үлдэгдлээс худалдан авахаар болон худалдахаар хүлээгдэж буй үнэт цаасыг хассан үнэт цаасны тоо гэж ойлгох

Гурав. Үнэт цаасыг төвлөрсөн хадгаламжид бүртгэх

- 3.1 СЗХ болон Засгийн газрын зөвшөөрөлтэй нээлттэй буюу нийтэд санал болгосон, хаалттай буюу тодорхой хүрээнд санал болгосон үнэт цаасыг үнэт цаас гаргагчийн хүсэлтийг үндэслэн Гүйцэтгэх захирлын зөвшөөрлөөр үнэт цаас гаргагчийн хадгалуулсан үнэт цаасны төрөл тус бүрээр бүртгэлийн дугаар өгч төвлөрсөн хадгаламж дахь “Үнэт цаасны бүртгэл” нэртэй дансанд бүртгэн хадгалах ба бүртгэлийн дугаар давхцахгүй байна. /маягт-1/
/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар Аймаг нийслэлийн Засаг даргын гэснийг хассан/
- 3.2 Алба нь үнэт цаасыг биет бус хэлбэрээр хадгална. Үүнд: 3.2.1 тусгайлан биет байдлаар хэвлээгүй, бүрдүүлбэр нь “ҮЦТХТ” ХХК-ийн төвлөрсөн хадгаламжийн цахим тооцоолуурын санах байгууламжид байгаа үнэт цаасыг биет бус үнэт цаасны хадгаламжид тооцно.
- 3.3 Алба нь СЗХ болон Засгийн газрын зөвшөөрөлтэй гаргасан нээлттэй буюу нийтэд санал болгосон үнэт цаасыг арилжаа эрхлэх байгууллагын мэдэгдэл, үнэт цаас гаргагчийн хүсэлтийг үндэслэн “Үнэт цаасны бүртгэл” нэртэй дансанд шилжүүлнэ.
/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар Аймаг нийслэлийн Засаг даргын гэснийг хассан/
- 3.4 Алба нь СЗХ болон Засгийн газрын зөвшөөрөлтэй гаргасан хаалттай буюу тодорхой хүрээнд санал болгосон үнэт цаасыг үнэт цаас гаргагчийн хүсэлтийг үндэслэн “Хөрөнгөөр баталгаажсан бонд” нэртэй дансанд шилжүүлнэ.
/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар 3.5-ыг хассан/

Дөрөв. Хадгаламжийн гэрээ

- 4.1 Хадгалагч нь хадгалуулагчтай хадгаламжийн гэрээ байгуулна. / Гэрээ-1/
- 4.2 Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5-т заасны дагуу хадгалагч нь хадгалуулагчийн үнэт цаасны бүрэн бүтэн байдлыг хангах үүрэг хүлээнэ.
- 4.3 Хадгаламжийн гэрээг бичгээр үйлдэх бөгөөд энэхүү гэрээнд хадгаламжийн хэлбэр, арилжааны хэлбэр, хадгалуулах үнэт цаасны төрөл, тоо ширхэг, хадгаламжийн үйлчилгээний хөлсний хэмжээ, төлөх хугацаа, үнэт цаас эзэмшигчдийн өмнө хүлээх үүрэг хариуцлага, ногдол ашиг тараах нөхцөл, бондын үндсэн болон хүүгийн төлбөр төлөх нөхцөл, хугацаа, график, хадгаламжийн гэрээг цуцлах нөхцөл, гэрээгээр хүлээсэнүүргээ гүйцэтгээгүйн төлөө талуудын хүлээх хариуцлагыг тусгасан байна. 4.4 Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хадгаламжийн гэрээнд заасан нөхцөлүүдэд өөрчлөлт орохоор бол үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээнд холбогдох нэмэлт үйлчилгээний төрлөөр өөрчлөлт оруулж болно.

Тав. Хадгаламжийн гэрээний хугацаа, үйлчилгээний хөлс

- 5.1 Хадгаламжийн гэрээний хугацаа нь гэрээ байгуулсан тухайн өдрөөс эхлэн тухайн жилдээ хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд үнэт цаасыг төвлөрсөн хадгаламжаас хасах тухай Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол болон Арилжаа эрхлэх байгууллагын мэдэгдэл ирээгүй, талууд гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэсээр байгаа тохиолдолд гэрээний хугацаа сунгагдана.
/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчлөн найруулсан/
- 5.2 Биет бус үнэт цаасны хадгаламжийн үйлчилгээний хөлсийг жилд нэг удаа үнэт цаасгаргагчаас авах ба хадгалагдаж буй үнэт цаасны зах зээлийн үнэлгээнээс хамааруулан тооцно. /Хавсралт-1/
- 5.3 Зах зээлийн үнэлгээг жил бүрийн 12-р сарын 31-ны өдрөөс өмнөх сүүлийн 52 долоо хоногийн дундаж ханшаар шинэчлэн тогтооно. Хэрэв сүүлийн 52 долоо хоногийн турш арилжигдаагүй бол хаалтын ханшаар тооцно.

Зургаа. Хадгалагдаж буй үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах

- 6.1 Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжинд хадгалагдаж буй үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орох /нэмж үнэт цаас гаргах, бүртгэлээс хасах, үнэт цаасыг хуваах, нэгтгэх, хөрвүүлэх/, үнэт цаас гаргагчийн бүртгэлд орсон өөрчлөлт /компани нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх зэргээр компанийг өөрчлөн байгуулах/-ийг бүртгэх зэрэг тохиолдолд дараах баримтуудыг үндэслэн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулна. Үүнд:
 - 6.1.1 Нийтэд нээлттэй санал болгосон үнэт цаасны хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахдаа СЗХ-ны тогтоол, шийдвэр, Арилжаа эрхлэх байгууллагын мэдэгдэл, ҮЦ хадгаламжаас хасах зөвшөөрөл /Маягт-2/, ҮЦ-ны хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулах зөвшөөрөл /Маягт-3/, Төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулах үйлчилгээний хөлс төлсөн байх, /Хавсралт-1/
/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчлөн найруулсан/
 - 6.1.2 Хаалттай хүрээнд санал болгосон үнэт цаасны хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахдаа СЗХ-ны тогтоол, шийдвэр, Үнэт цаас гаргагчийн хүсэлт, ҮЦ хадгаламжаас хасах зөвшөөрөл /Маягт-2/, ҮЦ-ны хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулах зөвшөөрөл /Маягт-3/, Төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулах үйлчилгээний хөлс төлсөн байх, /Хавсралт-1/
/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 9 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчлөн найруулсан/
 - 6.1.3 Энэ журмын 6.1.1, 6.1.2-д заасан Хороо, холбогдох эрх бүхий байгууллагын албан бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор үнэт цаас гаргагчийн бүртгэлд өөрчлөлт оруулах ажиллагааг хэрэжүүлнэ.
/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 12 дугаар тоот тогтоолын хавсралтаар шинээр нэмсэн/
- 6.2 Үнэт цаас гаргагч нь бүртгэлийн хэлбэрээ өөрчлөн үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасагдахад ногдол ашиг болон ногдол хувийн төлбөрийн тооцоог үнэт цаас гаргагчтай

гэрээний үндсэн дээр гүйцэтгэж, тооцоо нийлж дуусгана.

- 6.3 Арилжаа эрхлэх байгууллагаар арилжаалагдсан Засгийн газрын өрийн хэрэгсэл болон компанийн бондын хувьд арилжааны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэж буй байгууллагаас ирүүлсэн бондын үндсэн ба хүүгийн төлбөр төлөгдсөн тухай мэдэгдэл, үнэт цаас гаргагчтай төлбөрийн ямар нэгэн тооцоогүй тухай актыгтус тус үндэслэн үнэт цаасыг төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасна.
- 6.4 Бүртгэлийн хэлбэрээ өөрчлөх, нийлүүлэх нэгтгэх буюу өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдаж байгаатай холбогдуулан хувьцаа эзэмшигчдэд компаниас үнэт цаасаа эргүүлэн худалдан авах шаардах эрхийг хэрэгжүүлэх эрх үүсч байгаатохиолдолд хувьцааны төлбөр гүйцэтгэх гэрээг байгуулна.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчлөн найруулсан/

- 6.5 Гэрээний дагуу хувьцаа эзэмшигчдэд ногдох мөнгөн хөрөнгийг төвлөрсөн хадгаламжийн /ногдол ашиг, ногдол хувь/ дансанд байршуулсаны дараа Үнэт цаасгаргагч болон СЗХ-нд мэдэгдэнэ.
- 6.6 Тооцоо нийлээгүй, өр авлагатай, зээлийн барьцаанд болон шүүх, эрх бүхий байгууллагын шийдвэрээр тусгаарлагдсан үнэт цаасыг төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахгүй бөгөөд энэ тухай СЗХ, Арилжаа эрхлэх байгууллагад албан ёсоор мэдэгдэнэ.
- 6.7 СЗХ-ны бүртгэлээс хасагдсан үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг үнэт цаас гаргагч болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад тус тус ажлын 10 өдөрт багтаан хүргүүлнэ.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 12 дугаар тоот тогтоолын хавсралтаар шинээр нэмсэн/

Долоо. Мэдээ, тайлан, судалгаа

- 7.1 Алба төвлөрсөн хадгаламжинд хадгалагдаж буй үнэт цаас тус бүрээр хавтас нээн бүртгэл хөтлөх ба бүртгэлд өөрчлөлт оруулах тухай бүр мэдээ, тайланг гаргаж албаны өдрийн гүйлгээний баримтанд гүйлгээ хариуцсан ажилтан эх хувиар нь, хадгаламж хариуцсан ажилтан хуулбарыг холбогдох хавтсанд хадгална.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчлөн найруулсан/

- 7.2 Алба нь сар бүрийн гүйлгээний болон хадгалагдаж буй үнэт цаасны тухай тайланг гаргаж холбогдох журмын дагуу СЗХ-нд хүргүүлнэ.
- 7.3 Алба нь СЗХ болон хууль хяналтын байгууллага, үнэт цаас гаргагч, 5 хувиас дээш хувь эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр холбогдох мэдээ, судалгааг нууцын зэрэглэлтэйгээр болон нийтэд нээлттэй хэлбэрээр гаргаж өгч болно. Үүнд:

7.3.1 Гүйцэтгэх захирлын зөвшөөрлөөр, СЗХ болон үнэт цаас гаргагч, 5-аас дээш хувь эзэмшигчдийн хүсэлтээр нууцын зэрэглэлтэйгээр дараахи мэдээ судалгааг гаргах ба харилцагчийн дансны дугаартай мэдээллийг зөвхөн СЗХ-ны улсын байцаагчийн шаардлагаар гаргаж өгч болно.

7.3.2 Нууцын зэрэглэлтэй гаргах судалгаа

- Тухайлсан үнэт цаас гаргагчийн үнэт цаасны дэлгэрэнгүй судалгаа / Маягт-6/ /үнэт цаас эзэмшигчийн үнэт цаасны тоо ширхэг, нэр, регистрийн дугаар/
- Тухайн үнэт цаас гаргагчийн үнэт цаасны хувь эзэмшигчдийн судалгаа /үнэт цааснытоо ширхэг, нийт гаргасан үнэт цаасанд эзлэх хувь, нэр, РД/
- Үнэт цаасны балансыг өдөр бүрийн гүйлгээ өндөрлөсний дараа 1 хувь хэвлэн баримтын архивлалт хариуцсан ажилтан өдрийн гүйлгээний баримтанд хавсаргаан архивлана. /Маягт-5/

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчлөн найруулсан/

- ҮЦК-иудын харилцагчдын нэгдсэн мэдээ /VIPRO файл/-ҮЦК-иар үйлчлүүлж буй харилцагчдын талаарх мэдээллийг тухайн ҮЦК-ийн хүсэлтээр гаргаж өгнө.
- 7.3.3 Нийтэд нээлттэй гаргах судалгаа нь дараахи хэлбэртэй байна. Үүнд:
- Үнэт цаас эзэмшигч өөрөө хүссэн болон холбогдох хууль тогтоомжоор үүрэг хүлээсэн бол түүний эзэмшлийн үнэт цаасны талаархи мэдээлэл
 - Хувь хүний болон байгууллагын нууцад хамаарахгүй нийтэд мэдээлэх бүх төрлийн

судалгаа

- 7.4 Мэдээ, тайлан, судалгааны төлбөрийг журмын 2 дугаар хавсралтын дагуу тооцно.
- 7.5 Үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгааг хадгаламж хариуцсан ажилтан хянан судалгааны нүүр тус бүр дээр тэмдгээр баталгаажуулна. Мэдээлэл, судалгаа нь албаны захирлаар хянагдаж баталгаажна.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчлөн найруулсан/

- 7.6 Үнэт цаас эзэмшигчдийн хураангуй судалгааг албаны дарга тухайн үнэт гаргагчийн нийт зарласан болон гаргаагүй үнэт цаасны тоотой тулган хянан баталгаажуулах ба хадгаламж хариуцсан ажилтны баталгаажилтийг хянана./ Маягт-4/
- 7.7 Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгааг хүсэлт гаргасан этгээдэд шинэ системийг ашиглан гаргаж өгөхдөө арилжааны программын өөрчлөлттэй холбоотойгоор үнэт цаасны төлбөр бүрэн хийгдсэний дараа гаргаж өгнө.
- 7.8 Тайлан, мэдээ судалгааг хүсэлт ирүүлсэнээс хойш ажлын 3 хоногт багтаан хүсэлт гаргасан этгээдэд гарган өгөх бөгөөд хэрвээ хүсэлт гаргасан этгээд яаралтайгаар авах тохиолдолд нэмэлт үйлчилгээний хөлсийг төлж ажлын 1 хоногт гаргуулан авчболно.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар шинээр нэмсэн

- 7.9 Үнэт цаас гаргагч нь энэ журмын 7.3-д заасан үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгааг цаасан болон цахим хэлбэрээр авч болно.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар шинээр нэмсэн/

- 7.10 Энэхүү журмын 7.3, 7.9-д заасан судалгааг авахаар хүсэлт гаргасан үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-тэй үнэт цаасны хадгаламжийн гэрээ байгуулсан байх шаардлагатай бөгөөд үйлчилгээний аливааер төлбөргүй байна.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар шинээр нэмсэн/

Найм. Үнэт цаасны хадгалалт, хамгаалалт, нууцлалт

- 8.1 Хадгалагч нь хадгалж буй үнэт цаасны бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор файлхэлбэрээр хадгалагдаж байгаа биет бус үнэт цаасны өдөр бүрийн мэдээллийн баазыг холбогдох журмын дагуу тусгайлсан бүртгэл хөтөлж хадгална. Хуулбарлан архивлах үйл ажиллагааг Мэдээлэл Технологийн алба хариуцан ажиллах ба улирал бүрээр дараагийн улирлын эхний сарын 10-ны дотор албаны файл хэлбэрээр хадгалагдсан файлуудыг архивласан тухай акт үйлдэн нууцын эрхлэгчид хүлээлгэн өгнө.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчлөн найруулсан/

- 8.2 Бүртгэлийг хадгалагч байгууллагын нууцын эрхлэгч хөтлөх ба хамрах цаг хугацаа болон ямар файл хадгалагдаж байгааг дэлгэрэнгүй бүртгэнэ.
- 8.3 Албанаас архивлуулсан мэдээ судалгааг ашиглах тохиолдолд Дотоод хяналтад хүсэлт гарган ажлын 1 өдөрт багтаан задлуулан холбогдох мэдээллийг баталгаажуулан авч, акт үйлдэн ашиглана. Энэ талаар тусгайлан бүртгэл үйлдэж тэмдэглэл хөтлөн хавсаргана.
- 8.4 Хадгалагдаж буй үнэт цаас гаргагчийн талаарх мэдээллийг мэдээлэл ирүүлсэн тухай бүр үнэт цаасны хадгаламж хариуцсан ажилтан мэдээллийн санд шинэчлэн оруулна.
- 8.5 Хадгалагдаж буй үнэт цаасны мэдээллийн баазыг хадгалагч тал даатгалд хамруулж болно.
- 8.6 Албаны судалгаа шинжилгээний хадгалалт, нууцлалтыг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Монгол Улсын эрүүгийн хууль, “ҮЦТХТ” ХХК-ийн Нууцын тухай журам, мэдээллийн аюулгүй байдлын журмаар тустус зохицуулагдана.
- 8.7 Хадгалагдаж буй үнэт цаасны мэдээллийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдалд холбогдох албаны дарга, дотоод хяналт, нууцын эрхлэгч байнга хяналт тавьж ажиллана.
- 8.8 Системд өөрчлөлт оруулах аливаа тохиолдолд албаны даргын зөвшөөрлөөр Мэдээлэл Технологийн албанд бичгээр мэдэгдэнэ.

Ес. Анхан шатны баримтын хадгалалт, архивлалт

- 9.1 Албаны ажилтан ажил үүргийнхээ дагуу өөрийн хариуцсан гүйлгээ болон бусад бичиг баримт, мэдээ, судалгааг цаг хугацааны дараалал, гүйлгээний төрлөөр ангилан архивын шаардлагад нийцүүлэн архивлана.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчлөн найруулсан/

9.2 Архивласан баримтуудыг архивласнаас хойш ажлын 2 хоногт багтаан архивын ажилтанд хүлээлгэн өгч 2 хувь акт үйлдэнэ.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчлөн найруулсан/

9.3 Албанаас архивлуулсан мэдээ, судалгааг ашиглах тохиолдолд албаны даргын хүсэлтээр Гүйцэтгэх захирлын зөвшөөрлийг үндэслэн компанийн нууцын эрхлэгч архив задлуулж, акт үйлдэн ашиглуулна. Энэ талаар тусгайлан бүртгэл үйлдэж тэмдэглэл хөтлөн хавсаргаж хадгална.

9.4 бүтэн байдал, хадгалалт, архивлалтын горим зөрчигдсөн байдалд хариуцсан ажилтан бүрэн хариуцлага хүлээнэ.

9.5 Мэдээллийн санг өөрчлөн шинэчлэх байдалд албаны дарга хяналт тавина.

Арав. Хариуцлага

10.1 Албаны ажилтнууд компьютер дээрх файлыг санаатай болон болгоомжгүй үйлдлээр гэмтээсэн, устгасан, хадгаламжийн бүртгэлтэй холбоотой мэдээ судалгааг хувийн ашиг сонирхолд нийцүүлж боловсруулсан, бусдад тараасан, буруу болон хуурамч тодорхойлолт гарган хувь хүн болон байгууллагын нууцыг задруулбал хариуцлагыг бүрэн хүлээх ба журмын 9 дүгээр бүлгийн заалтуудыг зөрчвөл Гүйцэтгэх захирлын тушаалаар компанийн Дотоод журамд заасан сахилгын шийтгэл ногдуулна.

10.2 Энэ журмыг зөрчсөн үйлдэл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж зөрчсөн бол Санхүүгийн Зохицуулах Хороонд, Эрүүгийн гэмт хэргийн шинжтэй бол хууль хяналтын байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

10.3 Энэхүү журмын 7.9-д заасан судалгааг цахим хэлбэрээр авсан этгээд нь тус мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулснаас үүссэн аливаа эрсдэлийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК хариуцахгүй болно.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 07 дугаар тогтоолын хавсралтаар шинээр нэмсэн/

Арван нэг. Бусад

11.1 Хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт орсон тухай холбогдох мэдээлийг СЗХ-д хүргэж, тухай бүр нийтэд мэдээлнэ.

11.2 Энэхүү журамд ТУЗ-ийн тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж болно.

ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС

Хувьцаа

№	Үйлчилгээний төрөл	Суурь хураамж
1	Шинээр үнэт цаас бүртгэх	1,500,000

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар шинээр нэмсэн/

Хувьцаат компанийн хадгаламжийн жилийн үйлчилгээний хөлс

Зах зээлийн үнэлгээний шатлал	Үйлчилгээний хөлс
0,0 - 50,0 сая төг	100,000
50,001 - 200,0 сая төг	160,000
200,001 – 400,0 сая төг	220,000
400,001 сая – 700,0 сая төг	280,000
700,001 сая – 1,000,0 тэрбум төг	340,000
1 000,001 тэрбум төгрөгөөс дээш	400,000
*Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн Монгол улсад гаргах үнэт цаасны тоо ширхэгийг нэрлэсэн үнээр үржүүлсэн дүнгээс тооцох ба уг дүнгийн 0.2% байна.	
*Гадаадын улсын хуулийн этгээдийн үнэт цаасыг хадгалахдаа нийт үнэт цаасны тоо ширхэгийг нэрлэсэн үнээр үржүүлсэн үнийн дүнгээс тооцох ба уг дүнгийн 0.2% байна.	

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 12 дугаар тоот тогтоолын хавсралтаар шинэчлэн найруулсан/

Хувьцаат компанийн бүртгэлд өөрчлөлт оруулах үйлчилгээний хөлс

№	Үйлчилгээний төрөл	Үйлчилгээний хөлс
1	Оноосон нэр өөрчлөх	200,000
2	Үнэт цаас нэмж гаргах, хувьцаа хуваах, нэгтгэх г.мэт	500,000

Компанийн өрийн хэрэгсэл /бонд/

Хугацаа	Үйлчилгээний хөлс
Хугацаанаас үл хамааран	Үнийн дүнгийн 0.045 хувь

Аймаг, нийслэлийн Засаг даргын өрийн хэрэгсэл

Хугацаа	Үйлчилгээний хөлс
Хугацаанаас үл хамааран	Үнийн дүнгийн 0.05 хувь

Засгийн газрын өрийн хэрэгсэл

Хугацаанаас үл хамааран

Шатлал	Үйлчилгээний хөлс
0-10,000₮-ийн нэрлэсэн үнэтэй нэгж бонд	2₮
10,001-100,000₮-ийн нэрлэсэн үнэтэй нэгж бонд	20₮
100,001₮-с дээш нэрлэсэн үнэтэй нэгж бонд	50₮

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчилсөн/

МЭДЭЭ, СУДАЛГААНЫ ТӨЛБӨР

Мэдээ, мэдээллийн үнэ

/Эрх бүхий байгууллагын хүсэлтээр гаргасан мэдээ, мэдээлэл үнэ төлбөргүй/

Мэдээний нэр	Үйлчилгээний хөлс
*Үнэт цаас эзэмшигчдийн товчоо	Суурь хураамж 60 000 төг + хуудасны үнэ 100 төг
<u>*Үнэт цаас эзэмшигчдийн товчоо цахим хэлбэрээр авах</u>	<u>60 000 төг</u>
Тодорхой хувь болон ширхэгийн судалгаа	Хувь болон ширхэгээс хамааран 20 000-40 000 төг + хуудасны үнэ 100 төг (1% хүртэл – 40 000 төг , 1-5% - 30 000төг, 5%-иас дээш – 20 000 төг)
Хувьцаат компанийн тодорхойлолт	<u>10 000 төг</u>
Үнэт цаас эзэмшигчдийн хураангуй судалгаа	1 000 төг 1 000 төг
Боловсруулалт хийгдсэн нийтэд нээлттэй гаргах судалгаа- / 1 Хуудас нь /	12 000 төг
БДК-ийн VIPRO файл	
Ногдол ашиг тараалгах үйлчилгээний хураамж	<u>Суурь хураамж 40 000 төг</u> 1-10,000₮- төгрөгийн ногдол ашиг авах дүнд 0 төг 10,001₮ болон түүнээс их дүнд 50төг
Хувьцааны төлбөр гүйцэтгэх үйлчилгээний хураамж	<u>40,000 төг+ХЭ тоо*300 төг/</u>
Мэдээ судалгааг яаралтай авах тохиолдолд	<u>Үйлчилгээний хөлс + 10,000 төг</u>

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчилсөн/

БАТЛАВ: “ҮЦТХТ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
..... /

БАТЛАВ: “.....” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
..... /

ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖИЙН БОЛОН ҮНЭТ ЦААСТАЙ ХОЛБОГДОЛТОЙ ТӨЛБӨР ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

20.... онысарын ...

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Самбуугийн гудамж, 16/1 хаягт байршилтай “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (РД: 6043275) (цаашид “Хадгалагч” гэх), нөгөө талаас “.....” ХК (РД:.....) (цаашид “Хадгалуулагч” гэх) нар (хамтад нь “Талууд” гэх) харилцан тохиролцож дор дурдсан нөхцлөөр байгуулав.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар найруулга өөрчилсөн/

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Гэрээний зорилго нь хадгалагч нь хадгалуулагчийн хүсэлтийн дагуу гаргасан үнэт цаасыг нь хадгалах, хадгалуулагч хадгалагч талд хадгаламжийн үйлчилгээний хөлс төлөх, хадгаламжийн хугацаа, хадгаламжаас чөлөөлөх, хадгалуулсан үнэт цаастай холбогдолтой төлбөрийг зуучлан гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Хадгалуулах үнэт цаасны нэр, тоо ширхэг, хадгаламжийн үйлчилгээний хөлс

2.1 Хадгалуулагч нь төвлөрсөн хадгаламжид “.....” нэртэй ширхэг үнэт цаасыг хадгалуулах ба “ҮЦТХТ”-ийн “Үнэт цаасны хадгаламжийн журам”-ын 5.2-т заасны дагуу үйлчилгээний хөлсийг тухайн жилийн зах зээлийн үнэлгээнээс хамааран жил бүр шинэчлэн тогтооно. Үүнд: оны: Хадгаламжийн үйлчилгээний хөлс /үсгээр/ төгрөг байна.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар найруулга өөрчилсөн/

2.2 Хадгалагч тал үйлчилгээний хөлсний нэхэмжлэхийг 1-р улиралд багтаан хадгалуулагчийн бүртгэлтэй цахим шуудан /имэйл хаяг/-аар илгээнэ.

2.3 Хадгалуулагч тал хадгаламжийн үйлчилгээний хөлсийг 2-р улиралд багтаан төлнө.

2.4 Хадгалуулагчийн үнэт цаасны арилжаа зогссон нь үйлчилгээний хөлс төлөхгүй байх үндэслэл болохгүй.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар шинээр нэмсэн/

Гурав. Гэрээний хугацаа

3.1 Гэрээний хугацаа нь 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тухайн жилдээ хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд үнэт цаасыг төвлөрсөн хадгаламжаас хасах тухай Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол болон Арилжаа эрхлэх байгууллагын мэдэгдэл ирээгүй, талууд гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэсээр байгаа тохиолдолд уг гэрээний 8.1-д зааснаар гэрээний хугацаа сунгагдана.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолоор шинээр өөрчилсөн/

- 3.2 Хадгалуулагчийн гаргасан үнэт цаасны тоо хэмжээ нэмэгдсэн, буурсан, оноосон нэр өөрчлөгдсөн, аливаа өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд талуудын гаргасан хүсэлтийн дагуу гэрээг шинэчлэн байгуулна.
- 3.3 Гэрээний 3.2-т заасан санал, хүсэлтийг 1 сарын өмнө нөгөө талд зайлшгүй мэдэгдэнэ.

Дөрөв. Үнэт цаастай холбогдолтой төлбөрийг зуучлан гүйцэтгэх

- 4.1 Үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагааг Үнэт цаасны хадгаламжийн журмаар зохицуулна.
- 4.2 Үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэл нээж, үнэт цаастай холбогдолтой төлбөрийг шударга, ил тод, шуурхай хийж гүйцэтгэнэ.
- 4.3 Үнэт цаастай холбогдолтой төлбөр тооцоог “ҮЦТХТ” ХХК-ийн холбогдох журмыг удирдлага болгон гүйцэтгэнэ.

Тав. Хадгалуулагчийн эрх, үүрэг

- 5.1 Хадгалуулагч дараах эрхтэй:
- 5.1.1 Хадгалагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавих;
 - 5.1.2 Хувиарласан ногдол ашиг /болон ногдол хувь/-ийг үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийн дагуу хадгалагчаар зуучлуулан хувьцаа эзэмшигчиддээ тараалгах;
- 5.2 Хадгалуулагч дараах үүрэгтэй:
- 5.2.1 Хадгаламжийн үйлчилгээний хөлсийг жил бүр гэрээний 2.3-т заасан хугацаанд төлөх;
 - 5.2.2 Гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хангах;
 - 5.2.3 Хадгалуулагч үнэт цаас хадгалуулах талаарх хүсэлтдээ хавсаргасан мэдээ, материалын үнэн зөвийг хариуцах;

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар шинээр нэмсэн/

Зургаа. Хадгалагчийн эрх, үүрэг

- 6.1 Хадгалагч дараах эрхтэй:
- 6.1.1 Хадгалуулагчаас хадгаламжийн үйлчилгээний хөлс төлөхийг шаардах;
 - 6.1.2 Хадгалуулагчаас компанийн болон удирдлагын багийн тухай мэдээ, мэдээлэл гаргуулах;
 - 6.1.3 Хадгалуулагч тал нь тухайн жилийн хадгаламжийн үйлчилгээний хөлс төлөөгүй тохиолдолд хадгалагч тал аливаа мэдээ, судалгаа гаргах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах болон бусад үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;
- 6.2 Хадгалагч дараах үүрэгтэй:
- 6.2.1 Хадгалагдаж буй үнэт цаасны бүрэн бүтэн байдлыг хангах;
 - 6.2.2 Үнэт цаастай холбогдолтой төлбөрийг зуучлан тараах;
 - 6.2.3 Үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөх, бүртгэлийн үнэн зөвийг баримтаар хариуцах;
 - 6.2.4 Хадгалуулагчийн хүсэлтээр үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэлийг гаргаж өгөх;
 - 6.2.5 Хадгалуулагчийн хүсэлтээр хадгаламжийн журмын хавсралтаар батлагдсан гэрээний дагуу хувиарласан ногдол ашиг болон ногдол хувийг үнэт цаас эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд байршуулах;
 - 6.2.6 Хадгаламжийн болон бусад холбогдох үйл ажиллагааны журамд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг тухай бүр компанийн цахим хуудас /веб хуудас/-нд байршуулах;

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчилсөн/

Долоо. Талуудын хариуцлага

- 7.1 Хадгалагч хадгалуулсан үнэт цаасны бүрэн бүтэн байдлыг гэрээний хугацаанд хангаагүйгээс учирсан хохирлыг бүрэн хариуцна.
- 7.2 Хадгалуулагчийн буруугаас шалтгаалан гэрээ цуцлагдсан бол түүнээс үүдэн гарах хохирлыг хадгалагч тал хариуцахгүй.
- 7.3 Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ аль нэг тал биелүүлээгүй тохиолдолд гэрээг хугацаанаас өмнө

цуцлуулахаар нөгөө тал хүсэлт гарган өөрт учирсан хохирлоо нэхэмжлэх эрхтэй.
/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар найруулга өөрчилсөн/

Найм. Гэрээ дуусгавар болох буюу түүнийг цуцлах

8.1 Гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэн, талуудын аль нэг хадгаламжаас хасуулах тухай хүсэлт гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол болон Арилжаа эрхлэх байгууллагын мэдэгдлийг үндэслэн үнэт цаасыг төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хассанаар гэрээ дуусгавар болно.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчилсөн/

Ес. Бусад

9.1 Гэрээнд талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

9.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд эв зүйгээр зөвшилцөлдхүрэх замаар шийдвэрлэх ба зөвшилцөлд хүрч чадахгүй бол Монгол Улсын Шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

9.3 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох ба энэ тухай хүсэлтээ бичгээр нөгөө талдаа мэдэгдэнэ.

9.4 Гэрээний нэмэлт өөрчлөлт нь гагцхүү бичгээр үйлдэгдэж, талуудын бүрэн эрхт төлөөлөгч нар гарын үсэг зурсан тохиолдолд хүчин төгөлдөр гэж тооцогдоно. Ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчилсөн/

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Хадгалагчийг төлөөлж:

“ҮЦТХТ” ХХК-ийн
ХӨЭБКА-ны дарга

.....

Хаяг: Самбуугийн гудамж 16/1,
4 дүгээр хороо Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар 15141, Монгол
Утас: 70113671
Факс:70114424

Хадгалуулагчийг төлөөлж:

“.....”ХК-ийн

.....

.....

Хаяг:.....

.....

.....

Утас:

Факс:

“ҮЦТХТ”-Д ҮНЭТ ЦААС БҮРТГҮҮЛЭХ МАЯГТ

“ҮЦТХТ” ХХК-ийн ажилтан бөглөх	
	ISIN:
ОЛОН УЛСЫН ДУГААР:	CFI:

A. Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

1. Үнэт цаас гаргагчийн нэр	<input type="text"/>	2. Үсгэн код	<input type="text"/>
3. Байгууллагын хэлбэр	Нээлттэй	Хаалттай	
4. Бүртгэлийн огноо	<input type="text"/>	5. Газар/Улс	<input type="text"/>
6. Регистрийн	<input type="text"/>	7. УБ-ийн дугаар	<input type="text"/>
8. Үйл ажиллагаа явуулдаг салбар: /тохирох төрөл бүрт тэмдэглэгээ хийнэ үү/			
<input type="checkbox"/>	Хөдөө аж ахуй	<input type="checkbox"/>	Уул, уурхай
<input type="checkbox"/>		<input type="checkbox"/>	Аялал жуулчлал
<input type="checkbox"/>	Банк санхүү	<input type="checkbox"/>	Зам, барилга
<input type="checkbox"/>		<input type="checkbox"/>	Эрчим хүч
<input type="checkbox"/>	Худалдаа, үйлчилгээ	<input type="checkbox"/>	Эрүүл мэнд
<input type="checkbox"/>		<input type="checkbox"/>	Бусад
9. Албан ёсны хаяг	<input type="text"/>		
10. Утас	<input type="text"/>	11. Факс	<input type="text"/>
12. Имэйл хаяг	<input type="text"/>	13. Веб хаяг	<input type="text"/>
14. Компанийн дүрмийн сан		<input type="text"/>	
15. ТУЗ-ын даргын овог нэр		<input type="text"/>	
<input type="checkbox"/>	15а. РД	<input type="checkbox"/>	15б. Гэрийн хаяг
<input type="checkbox"/>	15в. Утас	<input type="checkbox"/>	15г. Имэйл хаяг
16. Гүйцэтгэх Захир лын овог нэр		<input type="text"/>	
<input type="checkbox"/>	16а. РД	<input type="checkbox"/>	16б. Гэрийн хаяг
<input type="checkbox"/>	16в. Утас	<input type="checkbox"/>	16г. Имэйл хаяг
17. Ерөнхий нягтлан бодогчийн овог		<input type="text"/>	
<input type="checkbox"/>	17а. РД	<input type="checkbox"/>	17б. Гэрийн хаяг
<input type="checkbox"/>	17в. Утас	<input type="checkbox"/>	17г. Имэйл хаяг
18. Нэмэлт тайлбар /шаардлагатай бол/		<input type="text"/>	

B. Үнэт цаас гаргагчтай холбоо барих мэдээлэл

1. Овог нэр	<input type="text"/>	2. Албан тушаал	<input type="text"/>
3. Утас	<input type="text"/>	4. Имэйл хаяг	<input type="text"/>

БАТЛАВ: “ҮЦТХТ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

БАТЛАВ: “.....” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

..... /

/

..... /

/

“ҮЦТХТ” ХХК-ИАР ЗУУЧЛУУЛАН НОГДОЛАШИГ ТАРААЛГАХ ГЭРЭЭ

20.... оны .. дүгээр сарын ...

№03/.....

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, “.....” ХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн нэг талаас Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг, Самбуугийн гудамж, 16/1 хаягт орших “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /цаашид зуучлагч гэх/, нөгөө талаас хаягт орших “.....” ХК /цаашид компани гэх/ бид дор дурьдсан нөхцлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү гэрээгээр компанийн хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг зуучлагчаар дамжуулан тараахтай холбогдон үүсэх талуудын эрх үүргийн харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Гэрээг зөвхөн компаниас ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтын дагуу ногдол ашгийг тараахаар байгуулна.
- 1.3 Ногдол ашгийн мэдэгдэл /**хавсралт-1**/, “.....” ХК-аас ирүүлсэн ногдол ашгаа авсан хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт /**хавсралт-2**/ нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

Хоёр. Талуудын эрх үүрэг

- 2.1 Компани дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
 - 2.1.1 Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ, бүртгэх өдөр болон ногдол ашиг тарааж эхлэх өдөр, ногдол ашгийг зуучлагчаар дамжуулан тараах тухай мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх;
 - 2.1.2 Гэрээнд гарын үсэг зурснаас хойш 3 хоногт багтаан ногдол ашгийн төгрөгийг “ҮЦТХТ” ХХК-ийн Төрийн банк дахь 341 303 332 956 тоот дансанд, Үйлчилгээний хөлс болох төгрөгийг “ҮЦТХТ” ХХК-ийн Төрийн банк дахь 102 100 549 647 тоот дансанд тус тус шилжүүлэх;
 - 2.1.3 Зуучлагчид гаргаж өгсөн ногдол ашгийн жагсаалтаас өөрөөр маргаан үүссэн тохиолдолдуг маргааныг бие даан шийдвэрлэх;
 - 2.1.4 Зуучлагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавих;

Гурав. Зуучлагчийн эрх, үүрэг

- 3.1 Зуучлагчийн дараах эрх, үүрэгтэй. Үүнд:
 - 3.1.1 Ногдол ашгийн мөнгө зуучлагчийн харилцах дансанд орсноос хойш ажлын 3 хоногт багтаан ногдол ашиг авах эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламжийн дансанд шилжүүлэх;
 - 3.1.2 Хувьцаа эзэмшигчдийн дансанд ногдол ашиг шилжүүлсэн тухай мэдээг компанид албанбичгээр болон өөрийн цахим хуудсаар хүргэх;

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

- 4.1 Ногдол ашгийн мэдэгдэл, ногдол ашиг авах хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтын үнэн зөвийг компани хариуцна.

Тав. Бусад зүйл

- 5.1 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг компани болон зуучлагч эв зүйгээр хэлэлцээр хийх замаар шийдвэрлэх ба талууд хэлэлцээр хийх замаар шийдвэрлэж чадаагүй бол маргаанаа МУ-ын шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.
- 5.2 Энэхүү гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгч нар гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 5.3 Энэ гэрээг 2 эх хувь үйлдэж, хоёр тал тус бүр нэг хувийг хадгалсан нь хуулийн адил хүчинтэй байна.
- 5.4 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах бол гагцхүү бичгээр үйлдэгдэж, талуудын бүрэн эрхт төлөөлөгч нар гарын үсэг зурсан тохиолдолд хүчин төгөлдөр гэж тооцогдоно. Ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 5.5 Гэрээтэй холбоотой бүхий л мэдэгдэл, зөвлөгөө хүсэлтийг талууд бичгээр дараах албан ёсны хаягаар илгээнэ. Үүнд:
Зуучлагчид хүргүүлэх бол
Хаяг: Чингэлтэй дүүрэг, Самбуугийн гудамж, 16/1, Утас: 70120460, Факс: 70114424
Мэдэгдэл хүргүүлэх эрх бүхий албан тушаалтан : Хадгаламж, өмчлөх эрх бүртгэл,кастодианы албаны дарга.....
Компанид хүргүүлэх бол
Хаяг: Утас: Факс:
Мэдэгдэл хүргүүлэх эрх бүхий албан тушаалтан :
.....

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Зуучлагчийг төлөөлж:

.....
/...../

ХӨЭБКА-ны дарга

Компанийг төлөөлж:

.....
/...../

НОГДОЛ АШГИЙН МЭДЭГДЭЛ

1. КОМПАНИЙН НЭР “ ” ХК
2. ХАЯГ
3. ХАРИЛЦАХ УТАС
4. ШИЙДВЭР ГАРСАН ОГНОО
5. ОЛОН НИЙТЭД ЗАРЛАСАН ОГНОО
6. ОЛОН НИЙТЭД ЗАРЛАСАН ХЭЛБЭР
7. БҮРТГЭХ ӨДӨР

-
8. БҮРТГЭГДСЭН ХУВЬЦААНЫ ТОО
 9. НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ
НОГДОЛ АШГИЙН ХЭМЖЭЭ

0.00₮-0.00₮/10% ХХОАТ/=00₮

10. “ҮЦТХТ” ХХК-иар
ЗУУЧЛУУЛАНТАРААХ
А. ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧИЙН ТОО
Б. ХУВЬЦААНЫ ТОО
11. “ҮЦТХТ” ХХК-иар ЗУУЧЛУУЛАН
ТАРААХНИЙТ ДҮН / 9 *10Б/
₮
12. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС
13. НИЙТ ШИЛЖҮҮЛЭХ МӨНГӨНИЙ ДҮН /11+12/ ₮

Мэдэгдэл гаргасан :
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ /

МЭДЭГДЭЛ ГАРГАСАН ОГНОО

Мэдэгдлийг хүлээн авсан
ҮЦТХТ-ийн ХӨЭБКА-ны ажилтан /

“.....” ХК-иас ногдол ашгиа авсан хувьцаа эзэмшигчдийн
жагсаалт

Д/д	Данс	Овог нэр	Регистр	Тоо ширхэг
	Нийт			

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/...../

20.....оны ... сарын

БАТЛАВ: “ҮЦТХТ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
..... /

БАТЛАВ: “.....” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
..... /

“ҮЦТХТ” ХХК-ИАР ЗУУЧЛУУЛАН ХУВЬЦААНЫ ТӨЛБӨР ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

20..... оны.... сарын

№ 04/.....

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24-р зүйлийг үндэслэн нэг талаас Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг, Самбуугийн гудамж, 16/1 хаягт орших “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /цаашид Зуучлагч гэх/, нөгөө талаас. “.....” ХК /цаашид Компани, хамтад нь талууд гэх/ нар дараахи нөхцөлийн талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү гэрээний зорилго нь компани бүртгэлийн хэлбэрээ өөрчлөх, нийлүүлэх нэгтгэх буюу өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдаж байгаатай холбогдуулан Компанийн хувьцаа эзэмшигчид Монгол Улсын Компанийн хуулийн 54, 55 дугаар заалт, СЗХ-ны оны сарын-ний өдрийн тоот тогтоолын дагуу шаардах эрхээ хэрэгжүүлэн өөрийн эзэмшиж буй хувьцаагаа Компанид эргүүлэн худалдах, Компани нь хувьцаа эзэмшигчдийн худалдахаар санал болгож буй хувьцааг худалдан авах, хувьцаа эзэмшигч нь шаардах эрхээ хэрэгжүүлэлгүйгээр хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг гаргахтай холбоотой төлбөр тооцоог Зуучлагчаар дамжуулан гүйцэтгүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчилсөн/

1.2 Хувьцааны төлбөр гүйцэтгэх мэдэгдэл /хавсралт-1/, компанид үлдэх хувьцаа эзэмшигчдийн бүртгэл /хавсралт-2/ нь гэрээний салшгүй хэсэг байна.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчилсөн/

Хоёр. Компанийн эрх, үүрэг

2.1 Компани нь Санхүүгийн зохицуулах хорооны 20..... оны-р сарын-ний өдрийн-тоот тогтоолын дагуу хувьцаа эзэмшигчийн мэдэлд байгаа нийт ширхэг хувьцааг эргүүлэн худалдан авах зорилгоор нийт ... төгрөгийг “ҮЦТХТ” ХХК-ийн Төрийн банк дахь 341 303 332 956 тоот дансанд байршуулсан байна.

2.2 Үйлчилгээний хөлс болох төгрөгийг “ҮЦТХТ” ХХК-ийн Төрийн банк дахь 102 100 549 647 тоот дансанд тус тус шилжүүлэх;

2.3 Нэгж хувьцааг эргүүлэн худалдах үнэ, бүртгэх өдөр болон хувьцааны төлбөр тарааж эхлэх өдөр, хувьцааны төлбөрийг зуучлагчаар дамжуулан гүйцэтгүүлэх тухай хувь нийлүүлэгчдэд мэдэгдэнэ.

2.4 Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх зориулалтаар Зуучлагчаас регистрийн дугаар, холбоо барих утас, гэрийн хаяг зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан тархалтын мэдээг СЗХ-ны тогтоол гарсан (цаашид “Бүртгэх өдөр”) өдрөөр тасалбар болгон гаргуулна.

2.5 Компани нь шаардах эрхээ хэрэгжүүлэн хувьцаагаа компанид худалдахаар хүсэлт гаргасан болон шаардах эрхээ хэрэгжүүлэхээс татгалзаж, компанид гишүүнээр үлдэхийг хүссэн хувьцаа эзэмшигчдийн талаарх бүртгэл, дэлгэрэнгүй мэдээллийг Зуучлагчаас гаргууланавах эрхтэй.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчилсөн/

2.6 Компани нь хувьцаа эзэмшигчээс “Хувь нийлүүлэгч нь шаардах эрхээ хэрэгжүүлэхээс татгалзаж хаалттай компанид хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлт” / хавсралт-3 /-ыг хүлээн авсан тухай бүр Зуучлагчид мэдэгдэх ба Улсын бүртгэлийн газарт хувь нийлүүлэгчээр бүртгүүлж өөрчлөлт оруулсан тухайгаа Зуучлагчид албан ёсоор мэдэгдэж бүртгэл хийлгэнэ.

2.7 Компани нь “Хувь нийлүүлэгч нь өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх хүсэлт” /хавсралт-4/-ийг өөр дээрээ хүлээн авах бол Зуучлагчаас батлан

гаргасан маягтын дагуу иргэний үнэмлэхний хуулбарын хамт албантоотоор Зуучлагчид хүргүүлж бүртгэлийг хийлгэнэ.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчилсөн/

2.8 Зуучлагчийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавих эрхтэй.

Гурав. Зуучлагчийн эрх, үүрэг

3.1 Энэхүү гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногт багтаан бүртгэх өдрөөр тасалбар болгон шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдийн төвлөрсөн хадгаламж дахь дансанд хувьцаа эргүүлэн худалдан авах мөнгийг байршуулна.

3.2 Хувьцаа эзэмшигч нь “Хувь нийлүүлэгч нь өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн авахыг компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх хүсэлт” ирүүлсэн тухай бүр хувьцааг нь Компанийн дансанд татан төвлөрүүлнэ.

3.3 Хувьцаа эзэмшигчээс ирүүлсэн “Хувь нийлүүлэгч нь шаардах эрхээ хэрэгжүүлэхээс татгалзаж хаалттай компанид хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлт”-ийг Компанид хүргүүлэх бөгөөд төвлөрсөн хадгаламж дахь данснаас хувьцаа худалдан авахаар байршуулсан мөнгийг буцаан татаж, Компанийн төвлөрсөн хадгаламж дахь дансанд байршуулна.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар найруулга өөрчилсөн/

3.4 Хувьцаа эзэмшигч нь “Хувь нийлүүлэгч нь шаардах эрхээ хэрэгжүүлэхээс татгалзаж хаалттай компанид хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлт” гаргаагүй, төвлөрсөн хадгаламжийн дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг 2 сарын хугацаанд өөрийн дансанд шилжүүлэх хүсэлт ирүүлээгүй бол бүртгэлээс хасагдсан компанийн хувьцаа эзэмшигчээр үлдсэнд тооцож төлбөр, тооцоог гүйцэтгэнэ.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 12 дугаар тоот тогтоолын хавсралтаар шинээр нэмсэн/

Дөрөв. Талуудын хариуцлага

4.1 Шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдийн дансанд хувьцааны төлбөр байршуулахтай холбогдон гарсан аливаа маргаантай асуудал, зуучлагчийн үйл ажиллагаатай холбоотой хувьцаа эзэмшигчдийн зүгээс гаргасан гомдлыг Зуучлагч хариуцан шийдвэрлэнэ.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар найруулга өөрчилсөн/

4.2 Компанид хүсэлтээ хүлээлгэж өгсөн хувьцаа эзэмшигчдийн баримтын бүрдэл, хувьцааны төлбөртэй холбогдон гарсан аливаа маргаантай асуудал, компанийн үйл ажиллагаатай холбоотой хувьцаа эзэмшигчдийн зүгээс гаргасан гомдлыг Компани хариуцан шийдвэрлэнэ.

Тав. Бусад зүйл

5.1 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд юуны түрүүнд эв зүйгээр хэлэлцээр хийх замаар шийдвэрлэнэ.

5.2 Хэлэлцээр хийх замаар шийдвэрлэж чадаагүй бол маргаанаа Монгол Улсын Шүүхээр шийдвэрлүүлнэ.

5.3 Энэхүү гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгч нар гарын үсэг зурсан өдөр хүчин төгөлдөр болно.

5.4 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох ба энэхүү гэрээний адил бичгээр үйлдэгдэж, талуудын бүрэн эрхт төлөөлөгч нар гарын үсэг зурсан тохиолдолд хүчин төгөлдөр болно. Ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“ҮЦТХТ” ХХК-ийг төлөөлж:

/...../

ХӨЭБКА-ны дарга

Хаяг: Улаанбаатар хот Чингэлтэй
дүүрэг, Самбуугийн гудамж, 16/1

Утас: 70120460

Факс: 70114424

“.....” ХК-ийг төлөөлж:

.....

.....

Хаяг:.....

.....

Утас:.....

Факс:.....

ХУВЬЦААНЫ ТӨЛБӨР ГҮЙЦЭТГЭХ МЭДЭГДЭЛ

1. КОМПАНИЙН НЭР “
2. ХАЯГ
3. ХАРИЛЦАХ УТАС.....
4. ШИЙДВЭР ГАРСАН ОГНОО
5. ОЛОН НИЙТЭД ЗАРЛАСАН ОГНОО6.
- ОЛОН НИЙТЭД ЗАРЛАСАН ХЭЛБЭР
7. БҮРТГЭХ ӨДӨР

8. БҮРТГЭГДСЭН ХУВЬЦААНЫ ТОО

9. НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ
НОГДОЛ ХУВИЙН ХЭМЖЭЭ

10. “ҮЦТХТ” ХХК-иар
ЗУУЧЛУУЛАН ТАРААХ
А. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ТОО
Б. ХУВЬЦААНЫ ТОО

11. “ҮЦТХТ” ХХК-иар ЗУУЧЛУУЛАН ТАРААХ
НИЙТ ДҮН / 9 *10Б / ₮

12. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС /40 000төг+10А*300төг/ ₮

13. НИЙТ ШИЛЖҮҮЛЭХ МӨНГӨНИЙ ДҮН

/11+12/ ₮Мэдэгдэл гаргасан

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ / /

МЭДЭГДЭЛ ГАРГАСАН ОГНОО

Мэдэгдлийг хүлээн авсан

ҮЦТХТ-ийн ХӨЭБКА-ны ажилтан / /

“.....” ХК-нд үлдэх хувьцаа эзэмшигчдийн жагсаалт

Д/д	Данс	Овог нэр	Регистр	Тоо ширхэг
1				
2				
3				
4				
5				
6				
	Нийт			

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /...../

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НЬ ШААРДАХ ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭС ТАТГАЛЗАЖ
ХААЛТТАЙ КОМПАНИД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧЭЭР ҮЛДЭХ ХҮСЭЛТ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 53-р зүйл, СЗХ-ныонысарын-ны өдрийн тоот тогтоолд заасны дагуу өөрт үүссэн шаардах эрхийг хэрэгжүүлэх хүсэлгүй байгаа тул төвлөрсөн хадгаламж дахь тоот дансанд байршуулсан“ “ХК-ийн хувьцааны төлбөр авахаас татгалзаж хаалттай компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэхээр хүсэлт гаргаж байна.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар тогтоолоор найруулга өөрчилсөн/

Хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчийн тухай мэдээлэл:

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр

Регистрийн дугаар

Оршин суугаа хаяг

Холбоо барих утас

Төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар

Эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо ширхэг

Гарын үсэг

Хүсэлт гаргасан огноо

..... ХК

Хүсэлтийг хүлээн авсан огноо

Хүсэлт хүлээн авсан -ийн ажилтан

ҮЦТХТ ХХК

ҮЦТХТ-д хүлээн авсан огноо

Хүсэлт хүлээн авсан ХӨЭБКА-ны ажилтан

Гүйлгээ хийсэн ХӨЭБКА-ны ажилтан

Хянасан ХӨЭБКА-ны дарга

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НЬ ӨӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭНАВАХЫГ КОМПАНИАС
ШААРДАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮСЭЛТ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 53-р зүйл, СЗХ-ны оны -р сарын - ны өдрийн тоот тогтоолд заасны дагуу өөрт үүссэн шаардах эрхийг хэрэгжүүлэх хүсэлтэй байгаатул төвлөрсөн хадгаламж дахь тоот дансанд буй “ ” ХК-ийн ширхэг хувьцааг эргүүлэн авахыг компанид зөвшөөрч, **хувьцааны төлбөр** авах хүсэлт гаргаж байна.

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар найруулга өөрчилсөн/

Хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчийн тухай мэдээлэл:

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр

Регистрийн дугаар

Оршин суугаа хаяг

Холбоо барих утас

Төвлөрсөн хадгаламж дахь дансны дугаар

Эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо ширхэг

Гарын үсэг

Хүсэлт гаргасан огноо

..... компани

Хүсэлтийг хүлээн авсан огноо

Хүсэлт хүлээн авсан компанийн ажилтан

“ҮЦТХТ” ХХК

“ҮЦТХТ” ХХК-д хүлээн авсан огноо

Хүсэлт хүлээн авсан ХӨЭБКА-ны ажилтан

Гүйлгээ хийсэн ХӨЭБКА-ны ажилтан

Хянасан ХӨЭБКА-ны дарга

ҮНЭТ ЦААС ХАДГАЛАМЖИД БҮРТГЭХ ЗӨВШӨӨРӨЛ №

СЗХ-ныоны сарын-ны өдрийнтоот тогтоол, “МХБ” ХК-ийн оны сарын ... – ны тоот мэдэгдлийн үндэслэн дараах үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрөв.

Үзүүлэлт		Үнэт цаасны бүртгэл
Үнэт цаасны код:		
Үнэт цаасны нэр:		
Үнэт цаасны төрөл:		
Нийт үнэт цаасны тоо : /ширхэг/		
Нээлттэй /хувьцаат компани/	Тоо /ширхэг/	
	Хувь /%/	
Хаалттай /хязгаарлагдмал хариуцлагатай/	Тоо /ширхэг/	
	Хувь /%/	
Төрийн эзэмшлийн үнэт цаас	Тоо /ширхэг/	
	Хувь /%/	
Нэрлэсэн үнэ: /төгрөг/		
Үнэт цаасны нийт үнийн дүн: /төгрөг/		

“ҮЦТХТ”-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

“ҮЦТХТ”-ИЙН ХӨЭБКА-НЫ ДАРГА

ҮНЭТ ЦААС ХАДГАЛАМЖААС ХАСАХ ЗӨВШӨӨРӨЛ №

СЗХ-ны оны сарын-ны өдрийн тоот тогтоол, МХБ ХК-ийн оны сарын -ны өдрийн тоот мэдэгдлийн үндэслэн дараах үнэт цаасыг бүртгэлээс хасахыг зөвшөөрөв.

Үзүүлэлт	Үнэт цаасны бүртгэл
Үнэт цаасны код:	
Үнэт цаасны нэр:	

Үнэт цаасны төрөл:		
Нийт үнэт цаасны тоо : /ширхэг/		
Нэрлэсэн үнэ: /төгрөг/		
Үнэт цаасны нийт үнийн дүн: /төгрөг/		
Ногдол ашиг тараасан эсэх:		
Тараасан бол	Тараасан онууд:	
	Нэгж хувьцаанд ногдох хэмжээ: /төгрөг/	
Ногдол Хувь та раасан эсэх:		
Тараасан бол	Тараасан он :	
	Нэгж хувьцаанд ногдох хэмжээ: /төгрөг/	
Хувьцаа эзэмшигчийн тоо:		

ҮЦТХТ-ИЙН ГҮЙЦЭТГЭХ

ЗАХИРАЛУЦТХТ-ИЙН

ХӨЭБКА-НЫ ДАРГА

**ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАМЖИЙН БҮРТГЭЛД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ №**

СЗХ-ны оны сарын-ны өдрийн тоот тогтоол, МХБ ХК-ийн оны сарын - ны өдрийн тоот мэдэгдлийг үндэслэн үнэт цаасны хадгаламжийн бүртгэлд дараах өөрчлөлт оруулахыг зөвшөөрөв.

Үзүүлэлт	Үнэт цаасны бүртгэл	Өөрчлөлт
Үнэт цаасны код:		
Үнэт цаасны нэр:		
Үнэт цаасны төрөл:		
Нэгжийн нэрлэсэн үнэ: /төгрөг/		
Нэмэгдсэн үнэт цаасны тоо		
Нэг бүрийн үнэ		
Дүрмийн санг нэмэгдүүлэх дүн		
Хасагдсан үнэт цаасны тоо		
Нэг бүрийн үнэ		

Дүрмийн санг хорогдуулах дүн			
Нийт гаргасан үнэт цаасны тоо : /ширхэг/			
Төрийн эзэмшил	Тоо /ширхэг/		
	Хувь / %/		
Дотоодын эзэмшил	Тоо /ширхэг/		
	Хувь / %/		
Гадаадын эзэмшил	Тоо/ширхэг/		
	Хувь/%/		
Үнэт цаасны нийт үнийн дүн /төгрөг/			

ҮЦТХТ-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ҮЦТХТ-ИЙН ХӨЭБКА-НЫ ДАРГА

ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДИЙН ХУРААНГУЙ СУДАЛГАА

Үнэт цаас Зарласан ширхэг:
 Бүртгэх өдөр : Гаргасан ширхэг:
 Судалгаа гаргасан огноо: Арилжигдаагүй ширхэг:
 Зөрүү:

№	ҮЦК код	ҮЦК-ийн нэр	Тоо ширхэг	Хувьцаа эзэмшигчдийн тоо ширхэг
1				
2				

/Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчилсөн/

Тусгаарлагдсан үнэт цаас:

Судалгаа гаргасан.....Хадгаламжийн ажилтан Судалгаа
хянасан..... ХӨЭБКА-ны дарга

БАЛАНСЫН ЗӨРҮҮТЭЙ ХК-ИЙН ЖАГСААЛТ

Хэвлэсэн огноо:

№	Код	Үнэт цаасны нэр	Нээгдсэн	Нээгдээгүй	Нийт гаргасан	Нийт зарласан	ТХД-ийн үлдэгдэл	Зөрүү
1								
2								
Дүн								

Баланс гаргасан: / /

Хянасан: / /

Үнэт цаас эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгаа

Үнэт цаасны нэр: Нийт зарласан хувьцааны тоо: Нийт гаргасан хувьцааны тоо:
Бүртгэх өдөр:

БДК:

Дугаар Овог Нэр Регисир Тоо ширхэг Тусгаарласан

2

1

Данс нээгдсэн : Нийт

/ Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 29 дүгээр тоот тогтоолын хавсралтаар өөрчилсөн/

Судалгаа гаргасан.....Хадгаламжийн ажилтан Судалгаа
хянасан..... ХӨЭБКА-ны дарга

ҮНЭТ ЦААС ЭЗЭМШЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ №

Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвийн төвлөрсөн хадгаламжид..... оны сарын-ны өдрийн байдлаар дараахи үнэт цаасыг эзэмшиж байгаа болохыг тодорхойлов.

Д/д	ХАРИЛЦАГЧИЙН НЭР	ДАНСНЫ ДУГААР	ХУВЬЦААНЫ НЭР, ТӨРӨЛ	ТОО ШИРХЭГ	ХУВЬ
1					

Жич: Дээрхи хувьцаанаас ширхэг хувьцаа нь 20.... оны сарын ны өдрийн албан бичгээр тусгаарлагдсан байна.

ХӨЭБКА-НЫ ДАРГА / /

TO:

Statement of securities ownership

This is to certify that the securities, which are being deposited at the Central Depository of the MCSD Co., Ltd, are owned by the following customer by the date of , 20.....

	NAME	ACCOUNT NUMBER	TYPE OF SHARE	QUANTITY	PERCENT
--	------	----------------	---------------	----------	---------

1					
---	--	--	--	--	--

EXECUTIVE DIRECTOR OF CENTRAL
SECURITIES DEPOSITORY Co.,LTD

/

/

